



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын I баг

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД:ХОА-2022/20-20-ШТА-ГА

Ховд хот

2022 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408

Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Аудитор: Ц.Гантулга

Цахим хаяг: Gantulgats@audit.gov.mn

Аудитор: У.Батчимэг

Цахим хаяг: Batchimegu@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээдэл.....	5
Ерөнхий зүйл.....	6
БҮЛЭГ 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн бодлоготой уялдсан ч төсвийг оновчтой төлөвлөөгүй, салбар зөвлөл чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	7
1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацааны бодлогыг орон нутагт хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд 2021-2024 онд 600 ажлын байр шинээр бий болгохоор тусгажээ.....	7
1.2 Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөөгүй, төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийг хүн амын тоо, ажилгүй иргэдийн тоог харгалзан хуваарилаагүй батлагдсан төсвийн дийлэнх хувийг үйл ажиллагааны бусад зардалд зарцуулахаар төлөвлөсөн нь байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх нөхцөлийг хангаагүй байна.....	8
1.3 Шинэ ажлын байрыг 832 иргэнээр бий болж, төлөвлөснөөс 138.6 хувиар биелсэн байна...	10
1.4 Аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай байна.....	9
БҮЛЭГ 2. Хөдөлмөр эрхлэлтийн сангаас олгосон зээлийн хэрэгжилт хангалтгүй, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт сул, бүртгэл мэдээллийн цахим системийг сайжруулах шаардлагатай байна.	12
2.1 Бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг орчин үеийн дэвшилтэт технологийн түвшинд хүргэх шаардлагатай байна.....	12
2.2 Гадаадын хөрөнгө оруулалтаар жижиг зээлд аж ахуйн нэгж байгууллагуудыг үе шаттайгаар хамрагдсан ч бусад сан хөтөлбөрөөр олгогдсон зээлийн эргэн төлөлт болон хэрэгжилт хангалтгүй ажлын байр төдийлөн нэмэгдээгүй байна.....	13
2.3 Сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлж түүний зарцуулалтад тавих дотоод хяналт сул байна	14
2.4 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа зохих түвшинд хэрэгжүүлж байна.....	18
2.5 Засгийн газраас Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хөтөлбөрт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн дэмжлэг болсон байна.....	19

Холбогдох байгууллагын санал:.....

Саналд өгсөн тайлбар:.....

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмчийн
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХҮЕГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХХҮГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
ХЭД	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХБИ	Хөглийн бэрхшээлтэй иргэн
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл
БСШУС	Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
МБС	Мэргэжлийн боловсролын сургалт
МАО	Мал аж ахуй
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
АБД	Ажлын байрыг дэмжих

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөдөлмөрийн зах зээлд мэргэжлийн нийлүүлэлт /аймаг/	7
Хүснэгт 2	ХЭДС-ийн орлого /2016-2021 оны төлөвлөгөө, гүйцэтгэл/	8
Хүснэгт 3	ХЭДС-ийн батлагдсан төсөвт төсөл хөтөлбөрт олгох санхүүгийн дэмжлэгийн эзлэх хувь /2016-2021 он/	9
Хүснэгт 4	Төсөл хөтөлбөрт хамрагдах иргэний тоо /батлагдсан, гүйцэтгэл/	9-10
Хүснэгт 5	Сангийн зарлагын дүнд төсөл хөтөлбөрт олгосон зээлийн эзлэх хувь /2016-2021 он/	10
Хүснэгт 6	Ажилгүйдлийн түвшин /улс, бүс, аймаг/	11
Хүснэгт 7	Ажлын байрны зуучлал, захиалга, зөвлөгөө, шинэ ажлын байрны тоо	12
Хүснэгт 8	Арилжааны банкаар дамжуулан олгосон зээл /2017-2021 он/	13
Хүснэгт 9	Татан төвлөрүүлсэн орлого /2016-2021 он/	14
Хүснэгт 10	Эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлд хамрагдсан иргэн, олгосон зээлийн дүн /2016-2021 он/	15
Хүснэгт-11	Хугацаа хэтэрсэн зээлийн авлага /2014-2018 он/	16
Хүснэгт 12	Хөгжил политехник коллежийн элсэлт, төгсөлт, ажил эрхлэлт	18
Хүснэгт 13	Ховд аймгийн Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлт	18

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Чандмань сумын ХБИргэний “компьютерийн үйлчилгээ” төсөл	15
Зураг 2	Манхан сумын ХБИргэний “Сүүний үйлдвэрлэл” төсөл	15
Зураг 3	Малчдын төсөл хөтөлбөрт хамрагдсан төсөл	15
Зураг 4	Үенч сумын залуучуудын гарааны “буйдан” төсөл	16
Зураг 5	Дөргөн сумын залуучуудын гарааны “давс үйлдвэрлэл”	
Зураг 6	Жаргалант сумын ажлын байрыг дэмжих төсөл “шинэ гутал”	16
Зураг 7	Хөгжил политехник коллеж	18

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилгыг чиглүүлж, аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд: • Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн хэрэгжилт хангагдсан эсэх • Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Монгол улсын засгийн газрын 320 дугаар тогтоолоор баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгасан төсөл, хөтөлбөр зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагууд, аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, сумдын хөдөлмөр халамж үйлчилгээний ажилтан, Статистикийн хэлтэс зэрэг байгууллагуудыг оролцуулан 2016-2021 оны үйл ажиллагааг хамруулан хөдөөгийн 14 сумдад томилолтоор ажиллаж холбогдох горим сорилыг хэрэгжүүлсэн болно.
Аудитын хязгаарлалт	Аудит хийх явцад төсөл хөтөлбөрөөс олгосон зээлийн хэрэгжилтийг түүвэрлэн хянахад Жаргалант сумын иргэдийн оршин байрлах хаяг тодорхой бус, өөрчлөгдсөн, “Ковид -19” цар тахлаас үүдэлтэй хэрэгжүүлсэн төслүүд зогсонги байдалд орсон, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтнүүд Улаанбаатар хотод нэгдсэн сургалтад хамрагдахаар цөөнгүй хугацаагаар явсан зэрэг асуудлууд нь аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, АДБОУС 300, 3000-3100-д нийцүүлсэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар “Төрийн аудит байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглав. Холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга судалгаа авах, харьцуулах, нэгтгэн дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул, аудитор Ц.Гантулга, У.Батчимэг нар гүйцэтгэв.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 2022 оны 04 дугаар сарын 25 -ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүлээн авч нэгтгэх бөгөөд аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

Хөдөлмөр эрхлэлт нь бодлогын тэргүүлэх чиглэл болохын хувьд аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

д/д	2016 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд	2017-2020 онуудад хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд	2021 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ
2	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ
3	Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
4	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр		
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр
8	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
9	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл	Хүүхэд хамгаалагч төсөл
10	Жижиг зээл	Жижиг зээл	Жижиг зээл

Хэрэгжилтийн нэгдүгээр үе шат нь 2016-2020 онд хэрэгжиж дууссан бөгөөд УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа -2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсантай холбогдуулан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг МУЗГ-ын 2021 оны 10 дугаар сарын 34 дүгээр тогтоолоор хүчингүй болгожээ.

Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийн харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж олгох тухай, Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

БҮЛЭГ 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн бодлоготой уялдсан ч төсвийг оновчтой төлөвлөөгүй, салбар зөвлөл чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацааны бодлогыг орон нутагт хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд 2021-2024 онд 600 ажлын байр шинээр бий болгохоор тусгажээ.


1.1.1 Аймгийн Стратеги төлөвлөгөөнд “Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ” гэж тусгасан нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын зорилго, зорилтуудын заалтуудтай уялдуулан баталсан байна.

Мөн аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар шинэ ажлын байрыг жил бүр 500, 2021-2024 онуудад 600 ажлын байр шинээр бий болгохоор тусгагджээ.

1.1.2 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажилтны тоог нэмэгдүүлэх, ажилгүйдлийн түвшнийг бууруулж “Зохистой ажлын байр”-ыг дээдэлсэн аймаг болох зорилтын дэвшүүлэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг анх удаа 2018 онд аймаг орон нутгийн санхүүгийн дэмжлэг болон, Европын холбооны санхүүжилттэй ТМБССД-2 төсөл болон Швейцарын хөгжлийн агентлагийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн мэргэжлийн арга зүй болон санхүүгийн дэмжлэгтэйгээр хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийгдсэн байна.

Судалгааны үр дүнгээр аймгийн хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлтийг ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, сумдын сум хөгжүүлэх төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, Засгийн газар, аймгийн ОНХС-ийн төсөл хөтөлбөрийн эх үүсвэрүүдээр судалж 2018-2024 онд 181 мэргэжлийн 3956 ажлын байр бий болгоно гэж үзсэн байна. Мөн 2018-2024 онд их сургууль төгсөх төгсөгчдийг мэргэжлээр нь нэгтгэсэн судалгаагаар 293 мэргэжлээр 4217 боловсон хүчин бэлтгэгдэж гаргахаар байна. Хүснэгт-1

Хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар нягтлан бодох бүртгэл, эрх зүйч, их эмч, бага ангийн багш, барилгын инженер, СӨБ, бизнесийн удирдлага, цахилгааны инженер, сувилагч гэсэн үзүүлэлтээр эрэмбэлэгджээ.



1.1.3 Орон нутгийн бодлого боловсруулах чиглэлээр аймгийн ЗДТГ, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн хорооны оролцоотойгоор 2016-2020 онуудад аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр батлуулсан хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байсныг 2021-2024 онуудад нэгтгэж Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймаг хөгжүүлэх үндсэн чиглэлд


тусгагдсан асуудлын хүрээнд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцааг сайжруулах, зохистой ажлын байрыг нэмэгдүүлэх” аймгийн дэд хөтөлбөр хэрэгжиж байна.

Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа ажилгүй иргэн, залуучууд, ахмад настан, ажил олгогчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зэрэг зорилтот бүлгүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг тусгажээ.

Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөөгүй, төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийг хүн амын тоо, ажилгүй иргэдийн тоог харгалзан хуваарилаагүй батлагдсан төсвийн дийлэнх хувийг үйл ажиллагааны бусад зардалд зарцуулахаар төлөвлөсөн нь байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх нөхцөлийг хангаагүй байна.

1.2.1 Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.1¹, ХЭДС-ийн төсвийн төслийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29.6-д²-д зааснаар тухайнд онд зарцуулах төсвийн төслөө боловсруулан ХХҮЕГ-т хүргүүлэн, сангийн орлого, зарлагыг Төсвийн тухай хуулийн 42.2³.1.а⁴-д заасны ХХҮЕГ-ын даргын тушаалаар жил бүрийн төсвийн хуваарийг батлан аймгийн ХХҮГ-т ирүүлсэн байна.

Өмнөх онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр арга хэмжээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн тоо мэдээлэл, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн хэрэгцээг тодорхойлон тооцож төсвийн төслөө боловсруулан дээд шатны байгууллагад хүргүүлжээ. Хүснэгт-2



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2021 оны төсвийн орлогыг ХЭД тухай хуулийн 22.1.1⁵, 22.1.2⁶, 22.1.5⁷, 22.1.7⁸, 22.1.8⁹, 22.1.9¹⁰-д зааснаар сангийн орлогыг улсын төсөв, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос санхүүжүүлэхээр баталжээ.

ХЭДС-ийн орлогыг 2016 онд 1103.9, 2017 онд 4 удаа тодотгож 1474.9, 2018 онд 4 удаа тодотгож 1528.2, 2019 онд 1 удаа тодотгол хийж 1966.7, 2020

онд 4 удаа өөрчлөлт оруулж 1656.5 сая, 2021 онд 3 удаа тодотгож 1318.5 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2016 онд 878.0, 2017 онд 1367.7, 2018 онд 1526.6, 2019 онд 1964.0, 2020 онд 1102.2, 2021 онд 1239.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөрт дэлхийн банкнаас орон нутгийн санаачилгын төсөлд 2020 онд 45.0 сая, 2021 онд 61.4 сая төгрөгийн санхүүжилт, ХБИ

¹ Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн жилд орон нутагтаа хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, тэдгээрт сан болон дэд сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өмнөх оны 7 дугаар сарын 1-ний дотор хүргүүлнэ”

² Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь улсын төсвөөс санхүүжүүлнэ

³ Төсвийн захирагчид төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно

⁴ Өөрийн төсвийн багцад хамаарах хөтөлбөр хооронд

⁵ Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө,

⁶ Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө

⁷ Гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл

⁸ Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр

¹⁰ Бусад эх зэсвэр

ажиллуулаагүйн төлбөрт 5.6-182.3 сая төгрөг, зээлийн эргэн төлөлтөөс 45.9-576.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийг төлөвлөхдөө төсөл хөтөлбөрт хамрагдах иргэнд зарцуулах сургалтын зардал, бусад үйл ажиллагааны зардал болох сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах, хөтөлбөр төслийн хяналт, үнэлгээний зэрэг зардлыг хэт өндөр төлөвлөсөн байна.

ХЭДС-ийн чиглэлээр төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэд олон байдаг тул батлагдсан төсвийн хэмжээнд олон хүнийг хамруулах зорилгоор төсөлд ирүүлсэн мөнгөн дүнгээс бууруулан олгож байгаа нь хөтөлбөрүүдийн үр дүнг бууруулахад тодорхой нөлөөлөл үзүүлж байна.

1.2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд аймгийн Засаг даргын 2016-2020 онд мөрийн хөтөлбөрт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг жилд 500, 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэл хөдөлмөр эрхлэлт дэмжих замаар жил бүр 600-аас дээш ажлын байрыг бий болгохоор тусгагдаж ХЭДС-ийн жил бүр зарцуулах санхүүгийн эх үүсвэрийг батлуулжээ. Хүснэгт -3

	2016	2017	2018	2019	2020	2021
Санхүүгийн дэмжлэг буюу зээлийн дүн	532.5	697.5	868	1189	964.5	392
Батлагдсан нийт төсөв	1095.8	1474.9	1528.2	1966.7	1656.5	1318.5
Батлагдсан төсвийн дүнд олгох зээлийн эзлэх хувь	48.6	47.3	56.8	60.5	58.2	29.7
Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд зарцуулах хувь	51.4	52.7	43.2	39.5	41.8	70.3

Эх сурвалж: ХХҮГ-ын санхүүгийн тайлан

Иргэдэд олгох санхүүгийн дэмжлэг буюу зээлийн хэмжээ батлагдсан төсвийн 29.7-60.5 хувь, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 39.5-70.3 хувийг эзэлж байна.

1.2.3 Засгийн газрын 375 дугаар тогтоолын 4.7¹¹ дахь заалтын дагуу санхүүжилтийг хуваарилдаг эсэхийг орон нутагт үзэх боломжгүй, ХХҮГ-аас сумдад санхүүгийн дэмжлэгийг жигд тэгш хүртээмжтэй байх зарчмыг баримтлаагүй сумдад хуваарилсан байна. Тухайлбал: Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийг хүн амын тоо, ажилгүй иргэдийн тоонд харьцуулан үзэхэд Булган, Дөргөн, Мянгад, Чандмань сумдад илүү хуваарилж дэмжлэгт хамруулжээ.

Ажлын байрыг нэмэгдүүлэхэд тухайн оны төсөвт төсөл хөтөлбөрт хамрагдах хүний тоо, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөдөг боловч ХХҮГ-аас хуваарилсан төсвийн хүрээнд төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ ирүүлсэн иргэдийг олноор хамруулах зорилгоор хэт жижиглэж олгож байна. Хүснэгт-4

хөтөлбөр	2016		2017		2018		2019		2020		2021	
	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц

¹¹ “Сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэн аймаг, нийслэл дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын саналыг харгалзан, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. Энэхүү хуваарийг санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 1 дүгээр сард багтаан хүргүүлж байна”

Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих	80	117	75	114	91	114	78	150	87	107	36	63
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	25	25	20	20	16	21	22	22	10	6	1	1
ХБИ	70	76	25	49	14	35	11	28	15	31	21	29
Малчдын хөдөлмөр эрхлэлт	65	65	56	66	65	76	62	70	49	53	17	19
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ			31	45	8	20	11	23	11	18	11	18
Орон нутгийн онцлогтой зорилтот төсөл					1	1	9	24				

Эх сурвалж: ХХҮГ-ын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгт дэх мэдээллээс харахад 2016 онд ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 80 иргэн 120.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан нь 1 төсөлд дунджаар 1.5 сая төгрөгийн эх үүсвэр ноогдож, гүйцэтгэлээр 117 иргэн 120.0 сая төгрөгийн зээл олгогдож дунджаар 1.0 сая төгрөг, 2021 онд 36 иргэн 180.0 сая төгрөгөөр батлагдаж дундаж нь 5.0 сая төгрөг байхад гүйцэтгэлээр 2.8 сая төгрөгийн зээл олгогдож байгаа нь төсвийн төлөвлөлт бодитой бус харагдаж байна.

Шинэ ажлын байр 832 бий болж, төлөвлөснөөс 138.6 хувиар биелсэн байна.


1.2.4 Ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөрт 2016 онд 1 иргэнд 1.5 сая төгрөг ноогдож байсан бол 2021 онд 5.0 сая төгрөг болж өссөн ч гүйцэтгэлээр олгож байгаа хүний тоо нэмэгдэж байгаа нь төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай төсвөө бүрэн авч чадаагүйгээс төсөл хэрэгжих боломж бүрэн бүрдэхгүй байна.

Батлагдсан төсвийн 42.5 хувийг 2016 онд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд зарцуулж байсан бол 2021 онд 69.6 хувийг зарцуулагдсан нь төсөл хөтөлбөрт олгох зээлийн хэмжээ өмнөх онуудаас буурсан үзүүлэлттэй байна. Хүснэгт-5



Төсвийг төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд зарцуулах хэмжээ 2021 онд нэмэгдсэн гол шалтгаан өмнөх оны төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр бүрэн олгогдоогүйтэй холбоотой өсжээ.

1.2.5 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэн ажилласны үр дүнд 2021 онд 832 хүн шинэ ажлын байртай болсон нь 2016 онтой харьцуулахад 53.8 хувиар өссөн, ажилгүйдлийн түвшин 15.1 хувьтай байсан бол 2021 онд 9 хувь болж 6.1 хувиар буурсан байна. Хүснэгт-6



Аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай байна.

1.3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан хөтөлбөр арга хэмжээ, ХХҮГ-ын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох асуудлуудыг бүрэн тусган ажиллаж байна.

1.3.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28¹²-д Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг 28.3¹³, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 2 дугаар тогтоолоор “аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг баталсны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, гишүүдийг томилон баталжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар нь нь 2017 онд 3 удаа, 2018 онд 2 удаа, 2019 онд 2 удаа, 2020 онд 2 удаа, 2021 онд 2 удаа хуралдаж хуульд заасны дагуу Малжуулах төсөлд хамрагдах сумдыг сонгон баталдаг, батлагдсан төсөв, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж санал боловсруулан ажиллаж байгаа ч тухайн онд хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна.

Мөн ХЭҮЗ-ийн дүрмийн 2 дугаар тогтоолын 2.1.5¹⁴-д заасны дагуу ХЭДС-ийн 2016-2021 онуудын хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргаагүй, орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдэд хяналт хэрэгжүүлэхэд шатахуун, томилолтын зардалд зарцуулсан ч томилолтоор ажилласан он, сар, өдөр жолоочийн замын хуудсанд тэмдэглэсэн өдөр хоорондоо зөрүүтэй хэрэгжүүлсэн ажлын тайлангүй, үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй байна.

1.3.3 Ховд аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг аймгийн ЗДТГ-ын хяналт үнэлгээ, шинжилгээний алба хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцааг сайжруулах, зохистой ажлын байрыг нэмэгдүүлэх аймгийн дэд хөтөлбөр 70 хувийн биелэлттэй байна гэж дүгнэжээ.

¹² Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл

¹³ Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрмийг ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагатай зөвшилцөн Засгийн газар, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл цаашид “Үндэсний зөвлөл” гэх) батална

¹⁴ Тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлт дэмжих дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудал хэлэлцэж зөвлөмж гаргах, сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр хэлэлцэж дүгнэлт гаргах

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30¹⁵ дугаар зүйлд заасны дагуу аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр баталсан хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт, аймгийн ЗДТГ, ХХҮГ болон салбарын байгууллагууд нь уялдаа холбоогүй, түүнийг тайлагнах ажил хангалтгүй байдалтай байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагаанд ХХҮЕГ-ын хяналт, мониторингийн газраас 2019 онд 1 удаа, аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2017, 2018, 2019 онд 3 удаа хяналт шалгалтыг хийгдэж алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмжийг хүргүүлсэн, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй дахин давтан гаргасаар байна.

Төрийн аудитын байгууллагаас жил бүрийн санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудит хийгдэж 2020 онд 69.4 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 50 хувьтай, 2021 оны аудитаар 124.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 46.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 2.8 сая төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 36.4 сая төгрөгийн албан шаардлага, 39.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн байна.

БҮЛЭГ 2 Хөдөлмөр эрхлэлтийн сангаас олгосон зээлийн хэрэгжилт хангалтгүй, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт сул, бүртгэл мэдээллийг цахим системийг сайжруулах шаардлагатай байна.

Бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг орчин үеийн дэвшилтэт технологийн түвшинд хүргэх шаардлагатай байна.

2.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8¹⁶ дугаар зүйл, 9¹⁷ дүгээр зүйл, Хөдөлмөрийн сайд, БСШУСайдын хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар “Ажил мэргэжлийн чиг баримжааг хөгжүүлэх 2016-2020 онд хэрэгжүүлэх чиглэлийн 1.2¹⁸, 1.2.1¹⁹, 1.2.2²⁰, 1.2.3²¹-д заасны дагуу зуучлалын болон зөвлөгөө өгөх үйлчилгээг хэрэгжүүлжээ. Хүснэгт-7

	Ажлын байрны зуучлал, захиалга			Ажлын байрны зуучлал/ ажлын байрны төрлөөр/			зөвлөгөө өгөх үйлчилгээ	
	захиалга	зуучлал	Шинэ ажлын байр	Байнгын	Улирлын	Түр	Ганцаарчилсан	Бүлгийн сургалт
2016	1278	980	448	626	5	349	71	1588
2017	1444	1335	554	823	170	342	182	1037
2018	1218	1132	640	755	200	117	248	2032
2019	1362	1227	814	687	217	223	283	2140
2020	1388	1240	828	600	269	371	581	1603
2021	1393	1186	832	461	368	357	456	1387
	8083	7100	4116	3952	1229	1759	1821	9787

¹⁵ Төрийн захиргааны төв байгууллага, Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

¹⁶ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ,

¹⁷ Ажилд зуучлах

¹⁸ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд дор дурдсан иргэнийг хамруулна

¹⁹ Хүүхэд, залуучууд

²⁰ Насанд хүрэгчид

²¹ Эмзэг болон эрсдэлтэй бүлгийн иргэн

Эх сурвалж нь ХХҮГ-ын үйл ажиллагааны тайлан

Ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас сул чөлөөтэй ажлын байрны 8083 захиалга авч 7100 гаруй ажилгүй иргэдийг ажлын байранд зуучлан аймгийн хэмжээнд 2016-2021 онд 4116 шинэ ажлын байрыг бий болгосон үүнээс байнгын 3952, улирлын 1229, түр ажлын байр бий болгожээ. /өссөн дүнгээр/

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө үйлчилгээг 1821 иргэнд ганцаарчилсан, 9787 иргэнд бүлгийн сургалт зохион байгуулж, 2021 онд ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээ өмнөх оноос 125, бүлгээрх зохион байгуулах үйлчилгээ 216-ээр буурсан үзүүлэлттэй байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Залуучуудад үйлчлэх загвар төв”-ийг байгуулан ажил хайгч залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох 5 модульт шинэ арга зүйгээр ханган сургалтыг зохион байгуулан 276 залууг хамруулан 160 гаруй залуучуудыг ажилд зуучилсан байна.

2.1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 16²², 17²³, 18²⁴-д зааснаар хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системд Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем буюу LMS программ хангамжийг 2013 оноос ашиглаж эхэлсэн ч программ хангамжид ажилгүйдлийн талаарх мэдээллийг оруулж байгаа ч сайжруулах шаардлагатай асуудлууд байна. Үүнд:

- LMS цахим программыг улсын хэмжээнд ашигладаг сар, улирал, жилийн эцсийн мэдээ тайлан нэгтгэх үед ачаалал ихэдсэнээс программ ажилладаггүй,
- Зарим үед мэдээ тайланг зөрүүтэй нэгтгээддэг,
- Программд төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн мэдээллийг бүртгэх цэстэй ч ажилладаггүй,
- Иргэн байгаа газраасаа бүртгүүлэх боломжгүй, заавал ХХҮГ-т биеэр болон утсаар ярьж бүртгүүлдэг
- Ажилгүй иргэн ажлын бус цагаар бүртгэлд хамрагдах боломж хязгаарлагдмал

ХЭДС-ийн орлого, зарлага, төсөл хөтөлбөрт хамрагдсан зээлдэгч, зээлийн эргэн төлөлт, төлөлтийн хуваарь, авлага, өглөгийн насжилтыг хамруулсан Explorer 3.52 программ хангамжийг сангийн өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

Уг Explorer 3.52 программ хангамж нь тухайн онд сангийн орлого зарлагын ажил гүйлгээг сар бүрээр шивж оруулдаг, төсвийн гүйцэтгэлийн тайланд тухайн оны орлогын төлөвлөгөө оруулах боломжгүй, сар бүрийн мэдээг нэгтгэн программаас гардаггүй, сумдын мэргэжилтэн өөрийн харьяаны төсөлд хамрагдаж байгаа иргэний зээлийн үлдэгдэл, зээл төлөх хугацааг харах боломжгүй дутагдалтай байна.

2.1.3 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний зардал ажилд зуучлал, чиг баримжаа зөвлөгөө өгөх, түр болон байнгын ажлын байр бий болгоход өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж зарцуулжээ.

Нийтлэг үйлчилгээний зардлыг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандарт, арга зүйн зөвлөмжийн дагуу ажил олгогчийн ажлын байрны захиалгын дагуу зөвлөгөө, өгөх үйлчилгээ болон ЕБС-ын ахлах ангийн 1597 сурагчдад ажил мэргэжлийн чиг олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэхэд батлагдсан төсвийг зарцуулж тайлагнажээ.


²² Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо

²³ Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан

²⁴

Гадаадын хөрөнгө оруулалтаар жижиг зээлд аж ахуйн нэгж байгууллагуудыг үе шаттайгаар хамрагдсан ч бусад сан хөтөлбөрөөр олгогдсон зээлийн эргэн төлөлт болон хэрэгжилт хангалтгүй ажлын байр төдийлөн нэмэгдээгүй байна.

2.2.1 Ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах зорилтын хүрээнд 2017 онд Голомт банкаар дамжуулан ХЭДС-ийн жижиг зээлд 66 иргэн аж ахуйн нэгж байгууллагад 649.5 сая төгрөгийн зээл олгогдож 48 байнгын ажлын байр, Дэлхийн банкны санхүүжилтээр 2019-2021 онуудад арилжааны банкт хамтран 97 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 951.5 сая төгрөгийн жижиг зээлийн санхүүгийн дэмжлэгт хамруулан 46 байнгын ажлын байр бий болгож үр дүнтэй хэрэгжиж байна. Дэлхийн банкнаас олгодог жижиг зээлд 2020 онд 54 иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж байсан бол цар тахлын үед 14 иргэн хамрагдаж 134.0 сая төгрөгийн зээл олгогдож өмнөх оноос 74 хувиар буурсан байна. Хүснэгт -8



2.2.2 Засгийн газрын 153 дугаар тогтоолд зааснаар сум хөгжүүлэх сангаас аймгийн 17 сумдад 2011-2021 онуудад 1478 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад өссөн дүнгээр 7669.0 сая төгрөгийг газар тариалан, мал аж ахуй, үйлдвэрлэлийн чиглэлээр зээл олгож, 976 ажлын байр хадгалагдаж, 4115.9 сая төгрөгийн зээл төлөгдөж, 3553.1 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, зээлийн эргэн төлөлтийн 864 иргэн хэвийн, 38 иргэний зээл хугацаа хэтэрсэн, 82 иргэн хэвийн бус, 497 иргэн муу төлөлттэй зээлдэгчид байна.

Аймгийн ОНХС-аас “Үйлдвэрлэгч Ховд” хөтөлбөрийн хүрээнд 2019-2021 онуудад 35 иргэн, аж ахуй нэгж байгууллагад 1187.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгогдож 2021 онд хамрагдсан 12 иргэн аж ахуйн нэгжид 30 гаруй байнгын ажлын байртай болсон, өмнөх оны төслийн хэрэгжилт хангалтгүй, зээлийн гэрээнд заасан хугацаанд зээл, зээлийн хүүгээ төлөөгүй байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

2.2.3 Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих талаар төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт хэрэгжүүлэх арга хэмжээ, заалтуудыг нарийвчлан тусган батлаагүй байна.

Ховд аймагт эмэгтэйчүүдийн ажиллах хүчин 2016 онд 19240, 2021 онд 18766 хүн буюу 474-ээр буурсан, ажилгүйдлийн түвшин 2016 онд 8.2 хувь байсан бол 2020 онд 6.7 хувьтай болж 1.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн ХХҮГ-аас 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “ур чадвартай эмэгтэйчүүд” төсөл боловсруулан ажиллах талаар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгуулахаар хүргүүлсэн нь дэмжигдээгүй боловч 2022 оноос ХХҮГ-аас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжихээр батлагдсан байна.

Сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлж түүний зарцуулалтад тавих дотоод хяналт сул байна.

2.3.1 Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1²⁵, 111.2²⁶ дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/83 дугаар тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийн 2.2.1.11²⁷ заасны дагуу ХБИ ажиллаагүйн төлбөр, зээлийн эргэн төлөлтийн орлогоор 2016 онд 51.4, 2017 онд 162.7, 2018 онд 303.9, 2019 онд 487.4, 2020 онд 383.4, 2021 онд 759.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ХХҮЕГ-ын дэд санд төвлөрүүлсэн байна. Хүснэгт-9



2.3.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-23.1.11-д хөдөлмөрийг дэмжих үйл ажиллагаанд 2016 онд 8 хөтөлбөрт, 2 арга хэмжээ, 2017-2020 онуудад 7 хөтөлбөр, 2 арга хэмжээ, 2021 онд Ковид-19 цар тахлын үед 3 арга хэмжээ, 5 хөтөлбөрт зарцуулах төсвийг батлан зарцуулжээ.

Сангийн хөрөнгөөс төсөл хөтөлбөрт хамруулан АБД хөтөлбөрт 701 иргэнд 1828.5, Малжуулах хөтөлбөрт 351 иргэнд 1546.5, Залуучуудын гарааны бизнест 73 иргэн 436.0, ХБИ-ний хөтөлбөрт 176 иргэнд 369.0, ахмад настны зөвлөх 126 иргэнд 199.5, орон нутгийн онцлогт төслийг 25 иргэнд 280.0 нийт 1452 иргэнд 4659.5 сая төгрөгийн зээлийг хөнгөлөлттэй эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгожээ. Хүснэгт- 10

он	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр		Малчдын хөдөлмөр эрхлэлт		Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес		ХБИ-ний ажлын байрыг дэмжих		Ахмад мэргэжилтний зөвлөх		Орон нутгийн онцлогтой зорилтот төсөл	
	иргэн	олгосон санхүүжилт	иргэн	олгосон санхүүжилт	иргэн	олгосон санхүүжилт	иргэн	олгосон санхүүжилт	иргэн	олгосон санхүүжилт	иргэн	олгосон санхүүжилт
2016	115	225.0	67	301.5								
2017	114	273.0	66	280.0	20	40.0	49	75.0	45	77.5		
2018	114	273.0	76	325.0	21	76.0	35	70.0	20	24.0	1	100.0
2019	150	391.0	70	310.0	22	220.0	28	55.0	23	33.0	24	180.0
2020	107	309.5	53	245.0	6	60.0	31	73.0	18	27.0		
2021	101	357.0	19	85.0	4	40.0	33	96.0	20	38.0		
ДҮН	701	1828.5	351	1546.5	73	436.0	176	369.0	126	199.5	25	280.0

Төсөл хөтөлбөрт олгосон зээлийг 2021 оныг 2019 онд харьцуулахад ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 8.7 хувиар, малчдын хөдөлмөр эрхлэлт олгосон зээл 3.6 дахин, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнес эрхлэлт 5.5 дахин буурсан үзүүлэлттэй байна.

²⁵ 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна.

²⁶ Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө

²⁷ ХБИ ажиллуулаагүйн төлбөр, хөтөлбөрүүдийн хүрээнд олгогдсон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг улирал бүрийн сүүлийн сарын 4 дэх долоо хоногт багтаан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлнэ.

ХЭДС-ийн хөрөнгөөр төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэн, аж ахуйн байгууллагын бараа бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор онлайн “чатпот” пэйж хуудсыг нээн ХХҮГ-ын дэргэдэх “Ховдод үйлдвэрлэл” борлуулалтын төвөөр төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэн аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг дамжуулан 2019 онд 28.7, 2020 онд 7.9, 2021 онд 14.2 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдээс дараах хөтөлбөрүүдийн хэрэгжилт орон нутагт хамгийн жишиг болохуйц үр дүнтэй байна. Тухайлбал:

- **ХБИ-ний төсөл хөтөлбөрт** хамрагдсан Манхан сумын Т.Отгондаваа “сүүний үйлдвэрлэл”-ийг чиглэлээр 3.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ тахианы аж ахуй, шахмал түлшний чиглэлээр туслах аж ахуй хөгжүүлсэн, Чандмань сумын ХБИргэн Б.Хишигбадрах “компьютерын үйлчилгээ”-ний чиглэлээр санхүүгийн дэмжлэгт хамрагдаж зээлээ гэрээний хугацаанд бүрэн төлсөн, сумын иргэд хөдөлмөрчдөд хэвлэлийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлэн тогтмол үйлчилгээ явуулдаг болсон,
- **Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт** аймгийн хэмжээнд 351 өрхийг хамруулан 40555 толгой мал худалдан авч малжуулсан нь малчдад мал сүргээ өсгөн нэмэгдүүлэхэд санхүүгийн хувьд үр дүнтэй хэрэгжиж, өрх бүрээс 2 иргэн бүрэн ажлын байраар хангагдсан,
- **Залуучуудын гарааны бизнесийн төсөл хөтөлбөрт** хамрагдсан Үенч сумын Г.Батбаяр. Б.Ууганбаяр нарын “Буйдан” төслийн хэрэгжилт сайн, үйл ажиллагаа нь тогтмолжсон өөрийн болон зэргэлдээ сумдын ард иргэдээс захиалга хүлээн авч бүтээгдэхүүнээ нийлүүлдэг, Дөргөн сумын Д.Түвшинсайханы “давсны үйлдвэрлэл”, Дарви сумын “сутайн хишиг цай” төслүүд хэвийн үйл ажиллагаагаа явуулж үйлдвэрлэл нэмэгдсэн,
- **Ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт** Үенч сумын иргэн Н.Булганцэцэгийн “оёдол” төрөл бүрийн зөөлөн эдлэлийн оёдлын үйлчилгээ явуулдаг, Жаргалант сумаас 2017-2021 онд 281 иргэнд 799.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, Тахилт багийн иргэн Б.Эрдэнэ-Олдохын “Шинэ гутал”, Хайрхан багийн иргэн М.Жавзаа “эко монгол хүүхдийн гутал”, Буянт багийн иргэн Б.Гантуяа “оёдол”, Цамбагарав багийн иргэн Даваанэмэх “алт мөнгөний дархан”, Бугат багийн иргэн Б.Гантулга “төмөр эдлэл”, Ө.Оролмаа “оёдол”, Хайрхан багийн иргэн Д.Баярмандах “вакум цонх” төслүүд хэвийн үйл ажиллагаа явуулж байна.

Харин Жаргалант сумын 12 багуудаас санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төсөл хөтөлбөртэй танилцахад төсөлд хамрагдах үед ирүүлсэн анхан шатны баримтад хавсаргасан хаяг дээрээ байдаггүй, холбогдох утасны дугаар өөрчлөгдсөн, Мөст сумын зээлдэгчид үйл ажиллагаа нь ерөнхийдөө зогсонги байдалтай байна.

ХЭДС-аас 2014-2021 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн зээлийн авлагын үлдэгдэл 2022 оны 5 дугаар сарын 01-ний байдлаар 2480.2 сая төгрөг, нийт авлагын 16.6 ХОА-2022/20-20-ШТА-ГА/



Зураг -1



Зураг-2




Зураг-3



Зураг-4



Зураг-5



Зураг-6

хувь нь буюу 413.1 сая төгрөгийн авлага, зээлийн гэрээнд тусгасан хугацаа хэтэрсэн байна. Хүснэгт-11

	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр		Малчдын ХЭД хөтөлбөр		ХБИ -ний ХЭД хөтөлбөр		Залуучуудын ХЭД, гарааны бизнес		Ахмадын зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх	
	хүний тоо	дүн	хүний тоо	дүн	хүний тоо	дүн	хүний тоо	дүн	хүний тоо	дүн
2014			1	1.3						
2015	53	39.5	3	6.8						
2016			3	4.0						
2017	50	54.1	10	24.0	25	35.9	4	4.5	11	14.7
2018	53	99.4	26	56.9		44.6	6	23.7	6	5.2
	156	193.0	42	91.6	25	80.5	10	28.1	17	19.9

ХЭДС-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан төсөл хөтөлбөрүүд хөдөө орон нутагт өөрөөр хэлбэл сумдад хэрэгжилт хэвийн явагдаж байгаа ч зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээнд тусгасан хугацаанд зээлээ төлөөгүй иргэдийг 2022 оны 3 дугаар сард хуулийн байгууллагад шилжүүлсэн, 19 иргэнтэй холбоотой 28.3 сая төгрөгийн төсөлд хэрэгжүүлэгч нас барсан байна.

Аудитын явцад 70 иргэнээс санал асуулга авч нэгтгэхэд ажил эрхлэхгүй байгаа гол шалтгаан нь цалин бага, ар гэрийн байдал, тохирох ажил олдохгүй байгаа, Ковид-19 цар тахлаас ажлын байргүй болсон, эрүүл мэндийн шалтгааны улмаас гэсэн хариулт өгөгдсөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн 2016-2021 оны нийт зарлагын 97.6 хувийг хөдөлмөр эрхлэлтийн зориулалтын зардал, 1.0 хувийг мэргэжлийн боловсролын зардал, 1.4 хувийг хөдөлмөр эрхлэлтийн хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

ХЭДС-ийн хөрөнгийг зарлагыг 2016 онд 1095.8, 2017-2020 онуудад 6626.3, 2021 онд 1318.5 сая төгрөгийг төсөл хөтөлбөрт зарцуулахаар батлагдаж 2016 онд 929.4, 2017-2020 онд 7382.5, 2021 онд 2059.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сангийн хөрөнгийн 2016-2021 оны зарцуулалтыг түүвэрлэн тулгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ХЭД-ийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3²⁸-д заасан заалтыг зөрчин 2017-2021 онуудад үндсэн хөрөнгө бэлтгэж 65.4 сая төгрөгийг зарцуулсан,
- Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1²⁹ гэсэн заалтыг мөрдөөгүй 40.4 сая төгрөгийг сургалтын цайны зардалд зарцуулж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан,
- 2016-2020 онуудад эд хариуцагчийн дансаар дамжуулан төсөл хөтөлбөрийн сургалт болон бусад үйл ажиллагааны зардалд бэлнээр гарган авч зарцуулсан ч бэлэн мөнгөний зарцуулалтын тайлангүй,
- Төсөлд хамрагчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг “Ховдод үйлдвэрлэв” борлуулалтын төвөөр дамжуулан худалдан борлуулж байгаа ч сар, улирал, жилээр хэчнээн хүний, хэдэн нэр төрлийн, хэдэн сая төгрөгийн бүтээгдэхүүн худалдан борлуулсан тооцоо мэдээ тайлангүй, хяналт хэрэгжүүлдэггүй,
- Албан хаагчдад сургалт зохион байгуулахдаа 1.6 сая төгрөгийн бал, дэвтэрт олгосон сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан,

²⁸ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг зориулалт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно

²⁹ Ажил олоход хүндрэлтэй иргэнд хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдаж хугацаанд нь хоол, унааны зардлын хөнгөлөлт үзүүлж, уг зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх


- Дотоод хяналт үнэлгээ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлийн гишүүдийн хяналт, төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалт зэрэг ажилд зарцуулсан шатахуунд тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй, жолоочийн тооцоо бодолт хангалтгүй,
- ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад зориулсан гарын авлага номыг хэвлэлийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаггүй компанид 6.5 сая төгрөгөөр хэвлүүлэхээр гэрээ байгуулахдаа хэдэн ширхэг номыг нэг бүрийг нь хэдэн төгрөгөөр хэвлүүлэх нь тодорхой бус, 2019 онд Хүүхэд залуучуудын оюуны хөгжлийг дэмжих шинэ алхам төв НҮТББ-аас хэвлүүлэх гэрээ байгуулаагүй 3.8 сая төгрөгийг сангийн хөрөнгөөс зарцуулсан,
- Сангийн үйл ажиллагааны гарын авлага, материал хэвлүүлэх зардлыг аж ахуйн нэгж байгууллага руу шилжүүлэн хүлээн авсан нь нотлогдохгүй дансаар дамжуулан 9.4 сая төгрөгийг зарцуулсан,
- Харилцагч байгууллагаас хувийн харилцах дансаар дамжуулан буцаалт нэрээр 1.8 сая төгрөгийг авч юунд зарцуулсныг нотлох баримтгүй,
- Шатахууны урамшуулал, материалын үнийн зөрүү буцаан авсантай холбоотой 1.3 сая төгрөгийн баримтгүй,
- Бусад гэрээт байгууллагад шилжүүлсэн мөнгөнөөс буцаан авч байгууллагын шинэ жилийн үйл ажиллагаа, ажилчдын биеийн тамирын хувцас авахад 5.7 сая төгрөгийг зарцуулсан,
- Тухайн оны жилийн эцэст их хэмжээний ажил гүйлгээ аж ахуйн нэгж байгууллага руу шилжүүлж уг ажил нь хийгдсэн эсэх нь тодорхой бус хүлээн авсныг нотлох боломжгүй 19.8 сая төгрөгийг зарцуулсан,
- Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын сургалтын зардлаас 2019 оны 9 дүгээр 27-30 ны өдрүүдэд “Нэг сум нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн зохион байгуулах, нутгийн зөвлөлийн гишүүд оролцох, Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтын удирдамж 10.6 сая төгрөгөөр батлан зарцуулсан, 2019 онд ХХҮГ-ын албан хаагчдыг Горны Алтайн их сургуульд 2 өдрийн сургалтад хамруулж төсөвт батлагдаагүй зардалд 8.9 сая төгрөг нийт 19.5 сая төгрөгөөр санхүүжүүлсэн,
- Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль журамд заасны дагуу ажлаа бүрэн хэрэгжүүлээгүй,
- ХЭДС-ийн хөрөнгөөр бараа материал худалдан авахдаа төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй орлого, зарлагын баримтад үндэслэн ажил гүйлгээг гаргасан,
- Байгууллагын үйл ажиллагааны тайлан, бусад брошур гарын авлага хэвлүүлэх зардалд 89.3 сая төгрөгийг урьдчилан шилжүүлж хэдэн ширхэг ирсэн нь тодорхой бус төлбөр шилжүүлсэн баримтад хавсаргаагүй дотоод хяналтгүй зарцуулсан,
- Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт, нээлт, бусад арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийн төсвийг үндэслэл муутай тооцож батлуулсан, зарцуулалтад тавих хяналт хэрэгжүүлээгүй,
- Ковид-19 цар тахалтай холбоотой аймгийн Онцгой комиссын захирамжаар 2020 оны 11дүгээр сарын 11-ээс эхлэн бүх нийтийн хөл хорио тогтоосон байхад сургалт зохион байгуулсан Саруул ухаан болон Сайн хүн ТББ-тай гэрээ байгуулан сургалтын зардал 13.3 сая төгрөгийг жилийн эцэст өглөг тусган 2021 онд төлбөрийг төлсөн уг сургалт бодитой хийгдсэн эсэх нь тодорхой бус

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа зохих түвшинд хэрэгжүүлж байна.

2.4.1 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв “Хөгжил политехник коллеж” нь 21 мэргэжлээр суралцагч элсэн суралцуулан Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар тогтоол, 2020 оны 44 дүгээр тогтоолын дагуу тэтгэлэгт 2019 онд 5856 суралцагчдад 585.6 сая, 2020 онд 6253 суралцагчдад 1250.6, 2021 онд 8054 суралцагчдад 1610.2 сая төгрөгийг Мэргэжлийн боловсрол сургалтын дэмжих сангаас олгожээ.



2.4.2 Ховд аймагт үйл ажиллагаа явуулж буй МБС-ын байгууллагын суралцагчийн тоо 2016 онд 528 байсан бол 2021 онд 818 болж өссөн нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар тогтоол, 2020 оны 44 дүгээр тогтоолын дагуу МБС-ын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгож эхэлсэнтэй холбоотой өссөн байна. Хөгжил политехник коллежийг 2016 онд 517 төгсөгч төгсөж 340 ажил эрхэлж байсан бол 2021 онд 602 төгсөгч төгсөж 422 төгсөгч буюу 70 хувь нь ажлын байраар хангагдсан байна. Хүснэгт-12



2.4.3 Бодлогын хэрэгжилтийг хангахдаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Хүснэгт-13

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувиар/	61.5	61.4	67.5	68.3	62.5
Ажиллагчид /хүн/	34,061	34,300	36,289	35,783	30,809
Ажиллах хүч /хүн/	40,117	39,669	39,626	40,356	33,260
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам /хүн/	15,236	16,200	14,021	12,007	16,029
Ажилгүй иргэдийн тоо /хүн/	6,055	5,367	3,337	4,572	2,451
Ажилгүйдлийн түвшин /хувиар/	15	14	8	11	7
Бүртгэлтэй ажилгүй иргэд /хүн/	1,515	1,156	991	1,005	821
15 ба түүнээс дээш хүний тоо	57,730	58,846	59,068	58,345	58,589
Ажлын шинэ байр	512	554	640	814	828

Эх сурвалж: www.1212.mn

Статистикаас харахад ажилгүй иргэдийн тоо 2016-2017 онд хамгийн өндөр өсөлттэй, 2020 онд хамгийн их бууралттай байх бөгөөд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо тогтмол буурсан үзүүлэлттэй байна.

Засгийн газраас Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хөтөлбөрт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн дэмжлэг болсон байна.

2.5.1 Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.5³⁰-д заасны дагуу Цар тахлын үед ажлын байрыг хадгалах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2020 онд 96 аж ахуйн нэгж байгууллагын 1399 даатгуулагчдад 835.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 2021 онд 556 аж ахуйн нэгж байгууллагыг 1146.0, 3615 сайн дурын даатгуулагчдад 381.6, нийт 1527.6 сая төгрөгийн чөлөөлөлт эдлүүлэн, сайн дурын даатгуулагчдад 18.5 сая төгрөгийн буцаалт хийсэн нь аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг дэмжсэн нь үр дүнтэй байна.

2.5.2 ХЭДС-аас малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт 2019 онд 70 иргэнд 310.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож байсан бол 2021 онд 19 иргэнд 85.0 сая төгрөгийн зээл олгосон нь 51 иргэн 225.0 сая төгрөгөөр багассан, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийн төсөл хөтөлбөрт 2019 онд 22 иргэнд 220.0 сая төгрөг олгогдож, 2021 онд 4 иргэнд 40.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамруулсан нь өмнөх оноос 18 иргэн, 180.0 сая төгрөгөөр буурч цар тахлын үед төсөл хөтөлбөрт хамрагдах иргэний тоо, санхүүгийн дэмжлэг буурсан байна.

2.5.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн 2020 оны 07 дугаар тогтоолын 2³¹-д заасны дагуу ХЭДС-аас 2021 онд 15 иргэнд 9.8 сая төгрөгийн хөнгөлөлт олгосон, тогтоолын 1³²-д заасны дагуу төсөл хөтөлбөрт хамрагдаж байгаа иргэдээс хүсэлт гаргуулан зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан талаарх нотлох баримтгүй байгаа нь ХЭДҮЗ-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.5.4 Цар тахлын үед ажлын чиг баримжаа зөвлөгөө авах иргэд 2019 онд 283, 2021 онд 456 иргэн болж өссөн нь 173 иргэнээр нэмэгдсэн нь цар тахлын үед ажлын байрны хомсдол бий болсон, ажилгүйдлийн түвшин 2019 онд 11.3 хувь, 2021 онд 9 хувь болж өмнөх оноос 2.3 хувиар буурсан, ажилд зуучлалаар байнгын ажлын байранд 2019 онд 687, 2021 онд 461 иргэн болж 226 иргэнээр буурсан бол түр ажлын байранд 2019 онд 223, 2021 онд 357 болж 133 иргэнээр нэмэгдсэн нь газар тариалан, мал аж ахуй чиглэлд түр ажилд хамрагдсан байна.

Аудитаар нийт 212.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 12.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 80.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 119.5 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөгдлөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

³⁰ цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх;

³¹ "Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ"-ээр тооцож, нэг удаагийн мөнгөн дэмжлэгийг тус тус нөхөн олгосугай

³² Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд 2017 онд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-т, 2018, 2019, 2020 онуудад олгосон эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хэвийн төлөлттэй иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг үндэслэн 2020 оны 12 сарын 01-ний өдрөөс эхлэн 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд сунгаж, хойшлуулсугай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд хөгжлийн бодлоготой уялдаж тодорхой үр дүнд хүрч байгаа ч сангийн орлогыг бодиттой төлөвлөөгүй, салбар зөвлөл чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт сул байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ :

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

ҮАГ-Т УЛАМЖЛАХ САНАЛ:

- ХХҮЕГ-ын хяналт мониторингийн газраас Ховд аймгийн ХЭДС-ийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх зөвлөмжийг нэгдсэн тайлангаар хүргүүлэх

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ ТАНАА

- Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөг оны эхэнд батлан түүний биелэлтийг улирал тутам дүгнэж цаашид авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх
- Салбар зөвлөл нь хуульд заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланг жилд 2 доошгүй хэлэлцэж, алдаа зөрчлийг арилгуулах ажил зохион байгуулах
- Хуульд заасны дагуу төслийн хэрэгжилтэд явцын болон гүйцэтгэлийн хяналт тавих хяналтын үр дүнг дээшлүүлэх

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ ТАНАА

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө, төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийг сумдын хүн амын тоо, ажилгүйдлийн түвшнийг харгалзан бодитой төлөвлөн хуваарилах
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор олгож байгаа зээлүүдийн эх үүсвэрийг үнийн өсөлттэй уялдан нэмэгдүүлэн олгох.
- Зээлийн гэрээнд тусгагдсаны дагуу 2015-2018 онуудад олгосон зээлийн эргэн төлөлтийг хуулийн байгууллагад бүрэн шилжүүлэн зээлийг төвлөрүүлэх
- Бүртгэл мэдээллийн цахим системийг сайжруулах, ажлын байрны мэдээллийг олон нийтэд сурталчлах ажлыг эрчимжүүлэх
- Сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бодитой төлөвлөж, зарцуулах, хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлж, зориулалтаар бусаар зарцуулахгүй байх,
- Аймгийн МХГ-аас хийгдсэн хяналт шалгалтаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах
- 2018 оны оны эцэст Эко Жаргалант ХХК, Хувь хүний хөгжлийн баруун бүсийн институттэй хийсэн гэрээний хэрэгжилт, гарын авлага, хэвлэлийн зардлуудад гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж, биелэлтийг тооцож ажиллах

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэн ажиллах ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг тооцон 2022 оны 09 дугаар сарын 01-ны дотор ирүүлэх

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 13

Ховд

**Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтууд, Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар "эрх үүрэг, шилжүүлэх тухай" тушаал, 2021 оны А/69 дугаар тушаал, 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Аудитаар илэрсэн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн Засаг дарга, Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт, тус тус хүргүүлсүгэй.

4. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2022 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/ Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга /Л.Билэгдэмбэрэл/-д зөвлөсүгэй.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитор /У.Батчимэг/-т үүрэг болгосугай

6. Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер, ахлах аудитор, аудитор нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

